



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн нэгдсэн эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2025/029/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Баруун-Урт сум 2025 он	Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Г.Даваа Утас: 70518396 Цахим хаяг: Davaag@audit.gov.mn Аудитын менежер: М.Нарантуяа Утас: 99029193 Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn Ахлах аудитор: С.Ариунбаяр Утас: 99076224 Цахим хаяг: Ariunbayars@audit.gov.mn
---	--

аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6 давхарт, Нутгийн удирдлагын 2 дугаар байр,
Балдан-Осорын гудамж, 7 дугаар баг,
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075
Утас: (976) 70518396
Цахим шуудан: sukhbaatar@audit.gov.mn

2025.02.25 № 84

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн нэгдсэн эмнэлгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар 2,064,461.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн бөгөөд эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалттай холбоотой 1,025,597.6 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн нь төсвийн гүйцэтгэлд үр дагавар үүсгэх эрсдэлтэй байгааг илэрхийлж байна. Өр төлбөрийн зохистой удирдлагын дутагдал, санхүүгийн төлөвлөлт, төсвийн төлбөрийн чадвар болон байгууллагын санхүүгийн байдалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй юм.

Аудитын гол асуудал

Өмнөх 2022, 2023 онуудад үүссэн томилолтын өрийг данс бүртгэлд тусгалгүйгээр албан хаагчдад нөхөн олгож, уг зардлыг тайлант хугацаанд зардал болгосон, мөн гэрээт ажлын хөлсийг нэхэмжилж авлагаар бүртгээгүйгээс зардлын бүртгэл болон тайлагналын

ил тод байдалд сөрөг нөлөө үзүүлжээ. Үүний үр дүнд алдаатай тайлагнал үүсч, санхүүгийн ил тод байдал болон үр ашигтай байдал алдагджээ.

Бусад асуудал

Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн "журам шинэчлэн батлах тухай" А/229 дугаар тушаалаар Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, Сангийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн "Ангилал шинэчлэн батлах тухай" А/211 дүгээр тушаалаар Төсвийн орлого, зардлын эдийн засгийн ангилал, санхүүгийн байдлын тайлангийн дансны жагсаалт шинэчлэгдсэнтэй холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогыг дахин боловсруулах нөхцөл үүссэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

The image shows a handwritten signature in black ink over a pink official stamp. The stamp contains Mongolian text and a central emblem. The signature is written in a cursive style.

Г.ДАВАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,752,537,286.71</u>	<u>1,867,917,538.38</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	70,817,029.95	94,648,837.45
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	70,817,029.95	94,648,837.45
3121	Төгрөг	70,817,029.95	94,648,837.45
31211	Төрийн сангийн харилцах	67,504,607.95	93,352,715.45
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	3,312,422.00	1,296,122.00
33	АВЛАГА	356,881,858.37	952,706,571.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	19,999.37	00.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	356,641,859.00	937,206,571.00
335	Бусад авлага	220,000.00	15,500,000.00
3351	Байгууллагаас авах авлага	220,000.00	15,000,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00.00	500,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,324,838,398.39	820,562,129.93
351	Түүхий эд материал	1,002,432,072.84	461,627,623.51
35130	Эм боох материал	1,002,432,072.84	461,627,623.51
354	Хангамжийн материал	322,406,325.55	358,934,506.42
35410	Бичиг хэргийн материал	1,913,820.00	3,114,750.00
35420	Аж ахуйн материал	13,963,414.15	16,889,737.45
35430	Сэлбэг хэрэгсэл	9,215,890.00	7,035,250.00
35440	Түлш, шатах тослох материал	13,952,465.00	9,494,277.00
35460	Хүнсний материал	18,975,866.41	3,430,802.98
35470	Бусад хангамжийн материал	264,384,869.99	318,969,688.99
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>11,641,939,856.47</u>	<u>11,674,056,361.27</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	11,641,939,856.47	11,674,056,361.27
392	Биет хөрөнгө	11,187,655,856.47	11,219,772,361.27
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,493,126,098.00	6,493,126,098.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-811,476,512.49	-1,008,157,927.80
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,054,397,781.00	1,518,166,481.34
39204	Хуримтлагдсан элэгдэл	-521,530,395.20	-682,497,000.39
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	11,799,512,661.11	13,392,989,829.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	-7,112,829,250.88	-8,702,860,511.03
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	753,851,424.32	762,363,778.32
39208	Хуримтлагдсан элэгдэл	-473,245,149.19	-559,051,336.75
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	3,000,000.00	3,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,500,000.00	2,500,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,562,500.20	-1,718,750.22
39217	Ном	1,911,700.00	1,911,700.00
393	Биет бус хөрөнгө	454,284,000.00	454,284,000.00
39301	Програм хангамж	600,000.00	600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-600,000.00	-600,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	454,284,000.00	454,284,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>13,394,477,143.18</u>	<u>13,541,973,899.65</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,191,290,913.22</u>	<u>1,184,793,172.61</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,191,290,913.22	1,184,793,172.61
413	Өглөг	1,191,290,913.22	1,184,793,172.61
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	330,000,000.00	00.00
4136	Бусад өглөг	861,290,913.22	1,184,793,172.61

41361	Байгууллагад төлөх өглөг	854,310,413.22	1,155,928,672.61
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	6,980,500.00	28,864,500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>12,203,186,229.96</u>	<u>12,357,180,727.04</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	12,203,186,229.96	12,357,180,727.04
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,682,328,865.24	3,682,328,865.24
51101	Өмч: - төрийн	3,682,328,865.24	3,682,328,865.24
512	Хуримтлагдсан үр дүн	5,161,575,616.60	5,315,570,113.68
51210	Өмнөх үеийн үр дүн	5,161,575,616.60	5,161,575,616.60
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	153,994,497.08
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,359,281,748.12	3,359,281,748.12
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>13,394,477,143.18</u>	<u>13,541,973,899.65</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	13,281,594,551.39	18,032,784,426.05
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,249,826,453.39	3,737,270,975.25
120	Нийтлэг татварын бус орлого	921,175,606.15	687,050,440.22
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	921,175,606.15	687,050,440.22
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	233,845,505.00	317,219,048.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	173,464,759.00	161,005,295.84
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	513,865,342.15	208,826,096.38
122	Тусламжийн орлого	1,328,650,847.24	2,080,106,135.03
122001	Хандив тусламж /дотоод/	1,328,650,847.24	2,080,106,135.03
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	00.00	970,114,400.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	00.00	970,114,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	11,031,768,098.00	14,295,513,450.80
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,000,000.00	43,280,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	43,280,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,000,000.00	00.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	11,021,768,098.00	14,252,233,450.80
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	11,021,768,098.00	14,252,233,450.80
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	14,483,290,536.37	17,878,423,969.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,483,290,536.37	17,878,423,969.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,468,304,574.37	17,859,373,814.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,599,420,279.62	8,354,785,662.77
210101	Үндсэн цалин	3,881,647,380.89	4,853,525,661.85
210102	Нэмэгдэл	2,016,247,743.83	2,534,117,115.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	192,840,000.00	306,744,000.00
210104	Урамшуулал	508,685,154.90	660,398,885.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	788,151,157.52	1,076,804,771.90
210201	Тэтгэврийн даатгал	553,986,565.97	737,700,839.19
210202	Тэтгэмжийн даатгал	65,152,802.45	89,113,352.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	50,269,841.54	65,119,943.10
210204	Ажилгүйдлийн даатгал	10,780,359.22	36,911,957.45
210205	Эрүүл мэндийн даатгал	107,961,588.34	147,958,679.65
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	848,155,668.97	923,897,831.84
210301	Гэрэл, цахилгаан	135,562,993.16	140,320,651.19

210302	Түлш, халаалт	602,818,025.81	612,720,580.65
210303	Цэвэр, бохир ус	109,774,650.00	170,856,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	415,266,910.48	332,324,954.20
210401	Бичиг хэрэг	34,960,550.00	40,594,155.00
210402	Тээвэр, шатахуун	162,791,100.00	189,348,021.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,406,326.40	7,372,731.80
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,640,500.00	9,664,444.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	207,468,434.08	85,345,602.40
2105	Нормативт зардал	3,623,116,856.45	4,714,942,852.53
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,274,183,275.80	4,377,961,319.20
210502	Хоол, хүнс	343,582,580.65	336,981,533.33
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,351,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	162,297,723.00	209,860,145.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	280,000.00	00.00
210604	Урсгал засвар	162,017,723.00	209,860,145.00
2107	Томилолт, зочны зардал	39,272,900.00	71,783,400.00
210702	Дотоод албан томилолт	39,272,900.00	71,783,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	67,592,078.98	27,715,035.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,105,700.00	13,118,736.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,464,425.00	2,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	742,807.48	497,557.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	679,000.00	231,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,957,942.50	3,118,038.50
210807	Газрын төлбөр	5,605,704.00	2,725,704.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	10,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	5,616,500.00	2,094,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,925,030,999.35	2,147,259,160.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,191,800.00	5,677,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,961,200.00	8,639,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,914,877,999.35	2,132,942,860.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,985,962.00	19,050,155.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,985,962.00	18,995,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,985,962.00	18,995,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	54,755.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	54,755.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-1,201,695,984.98</u>	<u>154,360,456.41</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,194,918,990.78	365,959.33
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,194,918,990.78	365,959.33
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-1,194,918,990.78	-365,959.33
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-2,396,614,975.76</u>	<u>153,994,497.08</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>11,139,378,910.40</u>	<u>15,148,287,482.05</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	406,490,671.40	1,433,338,743.25
120	Нийтлэг татварын бус орлого	406,490,671.40	463,224,343.25
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	406,490,671.40	463,224,343.25
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	233,845,505.00	317,219,048.00

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	172,645,166.40	146,005,295.25
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хооронд шилжүүлэг	00.00	970,114,400.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	00.00	970,114,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,732,888,239.00	13,714,948,738.80
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,000,000.00	43,280,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй хөрөнгөөс төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	43,280,000.00
131105	үндсэн үйл ажиллагааны орлого	10,000,000.00	00.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	10,722,888,239.00	13,671,668,738.80
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	10,722,888,239.00	13,671,668,738.80
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>11,214,034,083.36</u>	<u>15,039,136,484.55</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,214,034,083.36	15,039,136,484.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,193,652,621.36	15,007,332,644.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,269,399,789.71	8,685,308,026.40
210101	Үндсэн цалин	3,882,213,521.16	4,854,539,063.33
210102	Нэмэгдэл	1,816,488,563.94	2,716,554,835.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	192,762,000.00	306,743,824.13
210104	Урамшуулал	377,935,704.61	807,470,303.63
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	787,856,710.92	1,076,262,408.71
210201	Тэтгэврийн даатгал	553,692,119.37	736,223,218.58
210202	Тэтгэмжийн даатгал	65,152,802.45	89,098,304.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	50,269,841.54	66,107,868.40
210204	Ажилгүйдлийн даатгал	10,780,359.22	36,904,433.47
210205	Эрүүл мэндийн даатгал	107,961,588.34	147,928,583.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	658,080,268.97	1,100,348,800.00
210301	Гэрэл, цахилгаан	126,513,083.16	140,413,051.19
210302	Түлш, халаалт	412,846,125.81	801,499,138.81
210303	Цэвэр, бохир ус	118,721,060.00	158,436,610.00
2104	Хангамж, бараа материалын зардал	292,486,478.90	302,157,180.30
210401	Бичиг хэрэг	32,366,490.00	29,671,550.00
210402	Тээвэр, шатахуун	162,611,500.00	180,548,866.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,315,968.90	7,669,770.30
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	6,027,500.00	10,423,144.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	84,165,020.00	73,843,850.00
2105	Нормативт зардал	2,879,648,893.38	3,524,316,767.14
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,560,932,306.78	3,204,535,132.64
210502	Хоол, хүнс	288,335,986.60	305,368,914.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	30,380,600.00	14,412,720.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	174,489,139.00	210,115,315.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	26,563,950.00	28,420,500.00
210602	Тавилга	1,584,000.00	8,365,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,980,000.00	00.00
210604	Урсгал засвар	142,361,189.00	173,328,915.00
2107	Томилолт, зочны зардал	39,272,900.00	60,781,800.00
210702	Дотоод албан томилолт	39,272,900.00	60,781,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, төлбөр, хураамж	73,715,636.48	31,687,997.00
210801	БГНАҮТХураамж	55,403,700.00	13,118,736.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,464,425.00	2,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	742,807.48	497,557.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	679,000.00	231,000.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	1,765,000.00
210807	Газрын төлбөр	5,605,704.00	2,725,704.00
210808	Банк, санхүүгийн үйлчилгээний хураамж	00.00	10,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,400,000.00	7,420,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,702,804.00	16,354,350.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,836,800.00	7,114,750.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,866,004.00	9,239,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,381,462.00	31,803,840.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,381,462.00	31,749,085.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,381,462.00	31,749,085.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	54,755.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	54,755.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>-74,655,172.96</u>	<u>109,150,997.50</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	116,925,200.00	85,319,190.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	116,925,200.00	85,319,190.00
2200	Дотоод эх үүсвэрээр	116,925,200.00	85,319,190.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	116,925,200.00	85,319,190.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-116,925,200.00</u>	<u>-85,319,190.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-191,580,372.96	23,831,807.50
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	262,397,402.91	70,817,029.95
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	70,817,029.95	94,648,837.45

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	3,228,044,865.24	1,809,420,143.27	3,327,372,708.22	8,364,837,716.73
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,228,044,865.24	1,809,420,143.27	3,327,372,708.22	8,364,837,716.73
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-356,452,562.36	-356,452,562.36
C08	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	3,682,328,865.24	3,359,281,748.12	5,161,575,616.60	12,203,186,229.96
D01	2024 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	3,682,328,865.24	3,359,281,748.12	5,161,575,616.60	12,203,186,229.96
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,682,328,865.24	3,359,281,748.12	5,161,575,616.60	12,203,186,229.96
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	153,994,497.08	153,994,497.08
D09	2024 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	3,682,328,865.24	3,359,281,748.12	5,315,570,113.68	12,357,180,727.04

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгий	Үзүүлэлт	Тайлант оны
--------------	----------	-------------

Н ангила л		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,053,968,400.	14,109,156,574.
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,053,968,400.	14,109,156,574.
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,018,152,300.	14,079,423,789.
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,940,090,800.0	8,685,308,026.4
210101	Үндсэн цалин	5,178,454,700.0	4,854,539,063.3
210102	Нэмэгдэл	2,896,827,200.0	2,716,554,835.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	419,760,600.00	306,743,824.13
210104	Урамшуулал	445,048,300.00	807,470,303.63
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,191,748,900.0	1,076,262,408.7
210201	Тэтгэврийн даатгал	818,709,200.00	736,223,218.58
210202	Тэтгэмжийн даатгал	93,259,900.00	89,098,304.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	46,630,000.00	66,107,868.40
210204	Ажилгүйдлийн даатгал	46,630,000.00	36,904,433.47
210205	Эрүүл мэндийн даатгал	186,519,800.00	147,928,583.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	190,234,400.00	190,234,400.00
210302	Түлш, халаалт	190,234,400.00	190,234,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	356,750,000.00	291,877,180.30
210401	Бичиг хэрэг	20,333,000.00	29,671,550.00
210402	Тээвэр, шатахуун	171,450,000.00	170,268,866.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,700,000.00	7,669,770.30
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	21,667,000.00	10,423,144.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	136,600,000.00	73,843,850.00
2105	Нормативт зардал	4,015,810,400.0	3,526,866,767.1
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,703,813,100.0	3,207,085,132.6
210502	Хоол, хүнс	281,997,300.00	305,368,914.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	30,000,000.00	14,412,720.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	201,392,200.00	200,050,860.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	90,392,200.00	97,963,790.00
210602	Тавилга	18,000,000.00	21,591,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,000,000.00	00.00
210604	Урсгал засвар	90,000,000.00	80,495,270.00
2107	Томилолт, зочны зардал	60,833,600.00	60,781,800.00
210702	Дотоод албан томилолт	60,833,600.00	60,781,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,542,000.00	31,687,997.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,000,000.00	13,118,736.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,420,000.00	3,420,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,500,000.00	2,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	800,000.00	497,557.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	700,000.00	231,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,017,000.00	1,765,000.00
210807	Газрын төлбөр	2,880,000.00	2,725,704.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	600,000.00	10,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	7,625,000.00	7,420,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26750000.00	16354350.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,000,000.00	7,114,750.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,750,000.00	9,239,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35816100.00	29732785.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,816,100.00	29,732,785.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	35,816,100.00	29,732,785.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	15,053,968,400.00	14,134,893,082.05
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	13,460,327,500.	13,671,668,738.
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	13,460,327,500.	13,671,668,738.
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,593,640,900.0	463,224,343.25
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,335,541,600.0	317,219,048.00
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	204,271,900.00	146,005,295.25
120004 3	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	53,827,400.00	00.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	67,504,607.95
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	93,352,715.45
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	330.00	330.00
620001	Удирдах ажилтан	02.00	02.00
620002	Гүйцэтгэх ажилтан	255.00	255.00
620003	Үйлчлэх ажилтан	73.00	73.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		970,059,645.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		970,059,645.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		970,059,645.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		910,114,400.00
210301	Гэрэл, цахилгаан		140,413,051.19
210302	Түлш, халаалт		611,264,738.81
210303	Цэвэр, бохир ус		158,436,610.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		59,945,245.00
210604	Урсгал засвар		59,945,245.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 81,349.6 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 26,001.6 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

1. Тайлант онд албан томилолтоор ажилласан эмч, эмнэлгийн ажилчдын томилолтын тооцоог бүрэн хийгээгүйгээс 11,001.6 мянган төгрөгийн томилолтын нөхөн олговрын өр төлбөр үүссэн бөгөөд уг өрийг данс бүртгэлд тусгаж, үлдэгдлээр илэрхийлээгүй алдааг залруулж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулан өр төлбөрийг дансанд тусгуулж, зарлуулга хийлгэсэн
2. Баяндэлгэр, Сүхбаатар, Халзан сумын Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамруулсны төлбөр болох 15,000.0 мянган төгрөгийг бүрэн нэхэмжлээгүй, төлбөрийн үлдэгдлийг данс бүртгэлд авлагаар тусгаагүй байсан. Энэхүү алдааг тооцоо нийлсэн акт,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

гүйцэтгэсэн ажлын тайлан зэргээр баталгаажуулан данс бүртгэлд тусгуулсан байна.

Аудитаар нийт 55,348.0 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 24,980.9 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 30,367.1 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, ажлын цагийн тооцоотой холбоотой зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Төсвийн хөрөнгөөр 247.6 мянган төгрөгийн оргилуун дарс (согтууруулах төрлийн зүйл) худалдан авсан.

Илрүүлэлт: Эмч, эмнэлгийн ажилчдад илүү цагийн нэмэгдлийг дүрэм журмын дагуу бодоогүйгээс олгох ёстой хэмжээнээс 24,733.3 мянган төгрөгийг илүү олгосон зөрчил дутагдалд төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт: Дарга, санхүүгийн ажилтнуудад үр дүнгийн болон балансын урамшууллыг давхар олгосноор төсвийн зардал нэмэгдэж, санхүүгийн сахилга бат, урамшууллын ил тод байдалд сөрөг нөлөөтэй байна.

Илрүүлэлт: Өмнөх оны болох 2022, 2023 онуудад үүссэн томилолтын өрийг данс бүртгэлд тусгалгүйгээр албан хаагчдад нөхөн олгож, уг зардлыг тайлант хугацаанд зардал болгон бүртгэсэн. Үүний улмаас санхүүгийн тайлангийн бодит байдал алдагдаж, зардлын бүртгэл, тайлагналын ил тод байдалд сөрөг нөлөөлөл бий болж, алдаатай тайлагнал үүссэн байна.

Илрүүлэлт: Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал зардлаас эм эмнэлгийн хэрэгсэл болон спортын тэмцээний бооцооны төлбөрийг төлсөн нь эдийн засгийн ангилалд тохирохгүй зарцуулалт хийгдсэн бөгөөд төсвийг зохистой удирдаагүй байна

Илрүүлэлт: *Төсвийн хөрөнгөнөөс набор, ундаа худалдан авсан нь эдийн засгийн ангилалд тохирохгүй зарцуулалт байсан бөгөөд энэ нь төсвийн зарцуулалтын ангиллын дагуу зөв ангилж, батлагдсан зорилтуудыг хангаагүй байна. Үүний улмаас төсвийн үр ашгийг үнэлэх, тайлагнах үйл явцад зөрчил үүсэж, хяналтын тогтолцоо алдагдах эрсдэл үүссэн байна.*

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1³, 16 дугаар зүйлийн 16.5.5⁴, 41 дүгээр зүйлийн 41.2.2⁵, 41.2.3⁶, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.7⁷, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5⁸, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам”-ыг тус тус зөрчсөн байна.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

³ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

⁴ Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

⁵ батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;

⁶ төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах

⁷ байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах.

⁸ дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Ажлын цаг ашиглалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Эмч, эмнэлгийн ажилчид ERP цахим цагийн бүртгэлийг бүрэн хөтөлж, үйл ажиллагаандаа хэвшүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эмч, эмнэлгийн ажилчдад ERP цахим цагийн бүртгэлийг бүрэн хөтөлж, үйл ажиллагаандаа хэвшүүлэхийн тулд тогтмол сургалт зохион байгуулж, бүртгэлийн хяналтыг сайжруулж, системийн хүндрэлийг арилгах, хариуцлага хүлээлгэх, урамшуулал олгох болон тогтмол хяналт, үнэлгээ хийх;

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд Шилэн дансны тухай хуульд заасан 12 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Өгсөн зөвлөмж: Мэдээллийн ил тод байдлыг хангах, хугацаанд нь мэдээллийг оруулахын тулд тодорхой хариуцсан албан тушаалтнуудыг томилж, мэдээллийн цуглуулалт, боловсруулах, хугацаанд нь илгээх үүрэг хариуцлагыг баталгаажуулсан үйл ажиллагааны журам гаргаж, тогтмол хяналт, мониторинг хийх;

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр, биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл /мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Үүнээс				Зөвлөмж	
					Залруулсан		Залруулаагүй			
					Тоо	Дүн	Тоо	Дүн		
Авлага бүртгээгүй	1	15,000.0	1	15,000.0	1	15,000.0				
Өр төлбөр бүртгээгүй	1	11,001.6	1	11,001.6	1	11,001.6				
Дүн	2	26,001.6	2	26,001.6	2	26,001.6	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Согтууруулах ундаа худалдан авсан	1	247.6	1	247.6						
Нэмэгдэл илүү олгосон	1	24,733.3	1	24,733.3						

Урамшуулал давхардуулан олгосон	1	10,217.8			1	10,217.8				
өмнөх оны тооцоог нөхөж олгосон	1	9,166.5			1	9,166.5				
Төсвийн эдийн засгийн ангилалаар зарцуулаагүй	2	10,982.8			2	10,982.8				
Цагийн бүртгэл дутуу хөтөлсөн	1						1			
Дүн	7	55,348.0	2	24,980.9	4	30,367.1	1	-	0	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хугацаа хоцроож мэдээлсэн	1						1	
Дүн	1						1	